



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/89

Улаанбаатар хот

Дотоод заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоолын 2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан “Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх болон Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг шийдвэрлэх үйл ажиллагааны дотоод заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан зааврын дагуу үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Хүнд үйлдвэрийн бодлогын газарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Баасанпүрэв/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2018 оны “Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хавсаргах баримтын жагсаалт батлах тухай” А/105 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ГАНБААТАР

1508 01 0219

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2023 оны 04 дугаар сарын 04ний өдрийн
A/89 дугаар тушаалын хавсралт

Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэлт эрхлэх тусгай зөвшөөрөл болон

Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх, үйлдвэрлэлт эрхлэх тусгай
зөвшөөрөлтэй холбогдсон харилцааг шийдвэрлэх
үйл ажиллагааны дотоод заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дотоод зааврын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.
- 1.3. Тусгай зөвшөөрлийн өргөдөл, хүсэлтийг www.license.mn цахим системээр хүлээн авч шийдвэрлэнэ.
- 1.4. Үйл ажиллагааг зохион байгуулахдаа олон нийтэд ил тод нээлттэй байх, хариуцлага, туршлага, тогтвортой байдалд тулгуурлах зарчмыг баримтална.

Хоёр. Өргөдөл, хүсэлт хүлээн авах, хянах, шийдвэрлэх

- 2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын цахим системээр ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг тусгай зөвшөөрөл хариуцсан албан тушаалтан хүлээн авч дараах баримт бичгийн бүрдлийг хангасан эсэхийг шалгана. Үүнд:

- 2.1.1. Өргөдөл, хүсэлт, холбоо барих мэдээлэл
 - 2.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн лавлагаа
 - 2.2.3. Сүүлийн 3-н жилийн санхүүгийн товч мэдээлэл
 - 2.2.4. Аж ахуйн нэгж, байгууллагын татварын тодорхойлолт
 - 2.2.5. Улсын тэмдэгтийн хураамж
 - 2.2.6. Аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
 - 2.2.7. Аж ахуйн нэгж, байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга, үйлдвэрийн байршлын мэдээлэл /үйлдвэрийн гадна, доторх фото зураг/
 - 2.2.8. Удирдах болон мэргэжлийн инженер, техникийн ажилчдын мэдээлэл
 - 2.2.9. Сүүлийн 2 жилд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн
 - 2.2.10. Үйлдвэрийн технологи ажиллагааны товч танилцуулга /технологийн бүдүүвч/
 - 2.2.11. Машин, тоног төхөөрөмжийн жагсаалт, фото зургийн хамт
 - 2.2.12. Шаардлагатай тохиолдолд Байгаль орчны хяналтын байгууллагын дүгнэлт, Түрээсийн болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл
 - 2.2.13. Стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн жагсаалт
- 2.2. Баримт бичгийн бүрдэл дутуу ирүүлсэн тохиолдолд тайлбар хэсэгт үндэслэлийг бичиж, буцаах төлөвт шилжүүлнэ.
 - 2.3. Баримт бичгийн шаардлага хангасан хүсэлтийг хүлээн авч холбогдох газар, хэлтсийн даргаар хянуулахаар шилжүүлнэ.

- 2.4. Газар, хэлтсийн дарга нар тусгай зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн шаардлага хангаж байгаа эсэхийг ажлын 10 өдрийн дотор хянан шалгана.
- 2.5. Хянан шалгах үйл ажиллагаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан цахим хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 2.6. Шийдвэр гарсан өдрөөс хойш 5 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгосныг баталгаажуулан, шийдвэрийг тусгай зөвшөөрлийн цахим систем рүү оруулснаар тусгай зөвшөөрлийн QR кодтой гэрчилгээ автоматаар үүсэж 5 жилийн хугацаатай олгогдоно.
- 2.7. Тусгай зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээг аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр олгоно.
- 2.8. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол мэдэгдэлд татгалзсан үндэслэлийг тодорхой зааж, мэдэгдэл гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор зөвшөөрөл хүсэгчид бичгээр хүргүүлнэ. Энэ тохиолдолд тухайн зөвшөөрөл хүсэгчээс 6 сарын дотор өргөдөл хүлээж авахгүй.
- 2.9. Хянан шалгах ажиллагаанд шаардлагатай нэмэлт мэдээлэл, лавлагаа, дүгнэлт, тодорхойлолт зэргийг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан олж авах, солилцох боломжтой мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагаас шаардахгүй.

Гурав. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

- 3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө сунгуулах тухай өргөдлийг, хавсаргах баримт бичгийн хамт цахим системээр дамжуулан ирүүлнэ.
- 3.2. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, шаардлага хангаагүй эсхүл бүрдэл дутуу бол тайлбар хэсэгт үндэслэлийг бичиж, буцаах төлөвт шилжүүлнэ.
- 3.3. Баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа 10 хоног байх ба энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг сунгуулах тухай өргөдөл гаргаагүйд тооцно.
- 3.4. Баримт бичгийн бүрдэл хангасан өргөдөл, хүсэлтийг ажлын 5 өдрийн хугацаанд хянан шалгана.
- 3.5. Хянан шалгах ажиллагааг дууссанаас хойш ажлын 2 өдөрт багтаан тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 3.6. Шийдвэрийг тусгай зөвшөөрлийн цахим систем рүү оруулснаар тусгай зөвшөөрлийн QR кодтой гэрчилгээ автоматаар үүсэж 5 жилийн хугацаатай сунгагдана.
- 3.6. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан тохиолдолд, үндэслэл бүхий шийдвэрийг ажлын 2 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.
- 3.7. Аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах нөхцөл, шаардлагаас гадна татварын өргүй, байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалсан бол зөвшөөрлийн анх олгосон хугацааг 2 дахин нэмэгдүүлж сунгаж болно.
- 3.8. Өргөдөл, хүсэлтийг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзаж болохгүй.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

- 4.1. Аж ахуй нэгж, байгууллага нь шаардлагатай мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй эсхүл буруу гаргасан, тусгай зөвшөөрөл олгосноос хойш 2 жилийн хугацаанд

үйл ажиллагаа эрхлээгүй, мөн хууль, хяналтын байгууллагаас үйл ажиллагаа явуулахыг зогсоосон тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэнэ.

4.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тайлбар, мэдээлэл ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

4.3. Шийдвэрийн талаар аж ахуйн нэгж, байгууллагад болон харьяалах татварын албанад ажлын 2 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

4.4. Түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлт ирүүлсэн тохиолдолд, хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

5.1. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай аж ахуйн нэгж, байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

5.2. Аж ахуйн нэгж, байгууллага мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг ирүүлээгүй бол ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

5.3. Шийдвэрийн талаар аж ахуйн нэгж, байгууллагад болон харьяалах татварын албанад ажлын 2 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

---оо---